



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/650

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн техник хэрэгсэл нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу нийлүүлэгчээр шалгарсан “Саммит компьютер технологи” ХХК-тай 122 656 380 /Нэг зуун хорин хоёр сая зургаан зуун тавин зургаан мянга гурван зуун наяд/ төгрөгөөр гэрээ байгуулахыг эрхийг Аймгийн Иргэдийн төлөөлөгчдын хурлын Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д олгосугай.

2. Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Аймгийн Иргэдийн төлөөлөгчдын хурлын Нарийн бичгийн дарга (Б.Оюунболд)-д үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан барааг холбогдох хууль тогтоомж, стандарт, техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлж хүлээлгэн өгөхийг “Саммит компьютер технологи” ХХК-ийн захирал (Ш.Энхболд)-д даалгасугай.

4. Тус барааг хууль, журам, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны 09 сарын
13 өдрийн А/650 дугаар захирамжийн хавсралт

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Алданги	Хоногт гэрээний үнийн 0.1 хувь, нийт алданги гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
2	Бараа нийлүүлэх хугацаа	Гэрээнд зааснаар	Б.Оюунболд
3	Гүйцэтгэлийн баталгааны дүн	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь	Д.Батцогт